



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/ЗМ

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад тусгагдсан 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн төсөвт өртөгтэй Соёлын салбарын тоног төхөөрөмж (Өвөрхангай) төсөл арга хэмжээний 1 дүгээр багц “Аймгийн Хөгжимт драмын театрын уран бүтээлчдийн хувцас шинэчлэх зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх боломжгүй болсон тул орон нутгийн төсвөөс санхүүжүүлсүгэй.

2. Гэрээнд хяналт тавьж, гэрээнд тусгагдсан тоо хэмжээний дагуу уран бүтээлчдийн хувцсыг хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Ч.Гүнсэнхорол)-д даалгасгай.

3. Гэрээнд тусгагдсан 33,900,000 (гучин гурван сая есөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0667

D:My Doc. Zahiramj. Zasag darga